



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/18

Жавхлант

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ
сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан Жимобайл /5055873/-ын эзэмшлийн Баян-Овоо сумын Дэлгэрхаан багийн нутаг дэвсгэрт Хан Хөхий гэх газарт холбоо мэдээлэл дамжуулах, хүлээн авах станцын зориулалттай 200 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 жилээр сунган эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч Жимобайл /5055873 /-т даалгасугай.
3. Газар эзэмшигч Жимобайл /5055873 /-тай гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, сумын Газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Аюушсүрэн/-д үүрэг болгосугай.
4. Тухайн газрыг зориулалтын дагуу эзэмшиж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын дарга (Р.Оюунчимэг)-т даалгасугай.
5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны 80 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН